

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

*X.Нямбаатар*

Х.НЯМБААТАР

## “УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-Г БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. ҮНДСЭН НӨХЦӨЛ, ЗОРИЛГО

1.1. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний концепц, боловсруулалт хийгдэж буй хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж өгч, хот төлөвлөлтийн суурь судалгаа, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон төсөл хөтөлбөрийг газар ашиглалтын бүсчлэлийн үүрэг зориулалт, иргэний амьдрах орчныг сайжруулах, гэр хорооллын стратеги төлөвлөгөө, авто зам, тээврийн сүлжээ, ус хангамж, ариутгах татуургын систем, инженерийн бэлтгэл арга хэмжээ, гамшгийн менежмент, байгаль орчин, аялал жуулчлал, хог хаягдлын менежментийн салбаруудад боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, менежментийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль, Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030” (2015), Нэгдсэн Үндэстний Байгууллага, ХАБИТАТ байгууллагын “Хотжилтын шинэ хөтөлбөр” (2016), Монгол Улсын Үндэстний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010), Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (2011), “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого (2020), Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал (2020)-д заасан дараах зарчмуудыг баримтлан боловсруулах:

- үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- төр, иргэний хамтын ажиллагааг хангах;
- дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;
- даяаршлын хүчин зүйлийг харгалзах;
- нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;
- тэнцвэртэй байх;
- нөөц, эх үүсвэрт үндэслэсэн бодитой байх;
- ил тод, нээлттэй байх;
- судалгаа шинжилгээнд үндэслэсэн, мэдлэгт суурилсан байх;
- зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;
- шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;
- төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;
- төлөвлөлтийг дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах;
- бүх талын оролцоог хангасан байх;
- төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах;
- хотын хөгжил тогтвортой, цогц, хүртээмжтэй, хэмнэлттэй, өөрийн онцлог дүр төрхтэй, идэвхтэй (динамик), ирээдүйд үүсэж бий болох гэнэтийн нөхцөлүүдэд дасан зохицох боломжтой байх;

Дээрх зарчмуудыг баримтлан, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020), Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм (2011), Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (2000) болон хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулдаг олон улсын жишиг арга зүйг үндсэн үе шат, дарааллын дагуу боловсруулах.

1.2. Төслийн удирдлагын алба /ажлын хэсэг/ нь төслийн удирдлагын дөрвөн чиглэлийг хэрэгжүүлдэг:

- захиргааны;
- техникийн болон хууль эрх зүйн;
- санхүүгийн удирдлага, худалдан авалт;
- нийгмийн болон жендерийн хэмжигдэхүүн;

1.3. Төслийг боловсруулах, хэрэгжүүлэх үе шат бүрд олон нийтийн зөвшилцөл, оролцоог хангана.

1.4. Үйлчилгээний хамрах хүрээ: Нийслэл хотын нийт 470'000 га талбайг хамруулсан байна.

1.5. Үргэлжлэх хугацаа: Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 90 хоног;

## **2.ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь:

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, олон нийтийн хэлэлцүүлэг хийх, олон нийт болон оролцогч талуудын оролцоо, нүүлгэн шилжүүлэлт, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр мэргэшсэн байх;
- Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны барилга, нийтийн байгууламж, хотын үйлчилгээ, шугам сүлжээ, хотын зам, ус зайлуулах шугам, хот төлөвлөлт, хүлэмж, тохижилтын төлөвлөлт, сэргээгдэх эрчим хүч, инженерийн зураг төсөл, ажлын нөхцөл, шаардлагуудыг хангасан туршлагатай байх, тухайн чиглэлээр таван (5-10) жил ажилласан байх ёстой.

## **3.ТӨСЛИЙН АГУУЛГА**

2.2. Өнөөгийн нөхцөл байдлын судалгаа

2.3. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд дүн шинжилгээ хийж үнэлгээ, дүгнэлт өгөх;

2.4. Хотын хөгжлийн концепц,Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд зөвлөмж гаргах

2.5. Салбар бүрийн мастер төлөвлөгөө

- Газар ашиглалт (Газар зохион байгуулалт)
- Авто зам, тээвэр (Авто зам, Авто замын ус зайлуулах)
- Гэр хорооллын стратеги (Иргэдийн амьдрах орчныг сайжруулах)
- Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээ
- Гамшгийн менежмент (Гамшгаас урьдчилан сэргийлэх)
- Байгаль орчин, аялал жуулчлал, Хог хаягдлын менежмент (Байгаль орчин хамгаалах)

2.6. Олон нийттэй харилцах төлөвлөгөө

2.7. Судалгааны үр дүн, тайлан

Зөвлөх үйлчилгээ нь энэ нөхцөл, техникийн шаардлагад тодорхойлсон үйлчилгээнүүдийг багтаана. Ажлын даалгавар, шаардлагад заасан үүрэг даалгавар нь зөвхөн мэдээлэл, зааварчилгааны шинж чанартай бөгөөд Зөвлөх Үйлчилгээ үзүүлэгч нь мэргэжлийн мэдлэг, туршлага, олон улсын шилдэг туршлагаас олж авсан сургамжийг хэрэгжүүлэх, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой арга хэрэгслээр

хангах шаардлагатай. Гүйцэтгэгч байгууллага нь Монгол Улсын Засгийн Газар, Нийслэлийн Засаг даргын бодлого шийдвэрүүдэд нийцүүлэн төслийн ерөнхий чанарыг сайжруулж, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлуудыг нэмэгдүүлж болно.

#### 4.САЛБАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

##### 2.8. Газар ашиглалтын бүсчлэлийн үүрэг зориулалт

Газар ашиглалтын үр ашгийг дээшлүүлэхийн тулд үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны хүчин зүйл, газрын хуваарилалтыг авч үзэн, одоо байгаа газар ашиглалтын асуудлыг орон зайн талаас нь цогцоор нь шинжилнэ:

###### а) Үндсэн чиглэл

- Төв гудамжнуудын цаашдын өөрчлөлтийн чиг хандлага болон гол зам, нийтийн тээврийн одоогийн байдалд анализ хийх, хот доторх орон зайг хамгийн сайн ашиглах зарчмыг баримтална.
- Газар зохион байгуулалтад судалгаа хийж, үндсэн газар ашиглалтын асуудалтай талыг орон зайн талаас нэгдсэн байдлаар анализ хийн газрыг үр ашигтайгаар ашиглах төлөвлөгөө гаргана.

###### б) Төлөвлөгөө

- Газрын өнөөгийн нөхцөл байдал, хөгжүүлэлт хийх боломж, орчны бохирдол зэргийг судлан хөгжлийн төлөвлөгөөг гаргана.
- Хөгжлийн боломж, хамгаалалтын бүсийг бий болгож газар зохион байгуулалтын стратегийн санал дэвшүүлнэ.
- Хотын төвөөс гадна хөгжүүлэлт хийхэд хүндрэлтэй хотын захын бүсийг шинээр хөгжүүлэх төлөвлөгөө гаргах, нөөц чадавх ихтэй бүс, газрын нөөцийг үр дүнтэй стратегитэйгээр ашиглах боломжоор хангах талаас нь төлөвлөнө.
- Газрын хэрэгцээ, хүн амын нягтаршил болон аж ахуйн төлөвлөгөө зэргийг уялдуулан оновчтой төлөвлөлтийг хийх.

##### 2.9. Хотын тээврийн системийн төлөвлөгөө

Хотын орон зайн бүтэц, тээврийн онцлог, зэргэлдээх хотуудтай уялдаа холбоог сайтар нягтлан судалж хэрэглэгчдийн тав тухыг хангах үүднээс тээврийн хэрэгсэл болон хот тээврийн төлөвлөлттэй уялдуулан хөдөлгөөний ачааллыг бууруулах, иж бүрэн тээврийн системийн стратеги төлөвлөгөөг гаргана:

###### а) Үндсэн чиглэл:

- Хотын зам талбай, орон зай болон нийтийн тээврийн онцлог, ойролцоох хоттой. холбогдох холболтыг судлах, Улаанбаатар хот болон орон нутаг хоорондын зам тээвэр болон хотын доторх замын холболтын төлөвлөгөөг гаргана.
- Хотын авто зам харилцааг газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан. төлөвлөснөөр шаардлагагүй замын ачаалал нэмэгдлийг багасгана.
- Зам тээврийн байгууламжууд нь хэрэглэгчийн тав тухыг хангасан байхаар нэгдсэн. байдлаар төлөвлөгөөг гаргана.
- Хотын зам тээврийн нэгдсэн систем бий болгох
- Хот доторх авто зам, төмөр зам, явган хүний зам талбай, зогсоол зэрэг зам тээврийн. байгууламж төлөвлөлтийн өнөөгийн байдлыг судалж анализ хийж үзнэ.
- Хотын авто замын онцлог, авто замын уулзваруудын өнөөгийн байдал болон зам. тээврийн түгжрэл, доголдлын шалтгааныг тогтоох, анализ хийж ирээдүйг төлөвлөнө.

- Ойролцоох хотоос Улаанбаатар хоттой холбох хурдны замуудыг хөгжүүлэх, төлөвлөгөөг гаргах.
- Улаанбаатар хотын төв гудамжны замуудыг баруун гарын дүрмээр зохицуулагдах байдлаар төлөвлөж хөндлөн огтолсон замын төлөвлөлтийг аль болох тойрог авто зам бий болгох төлөвлөлтийг хийнэ.
- Төмөр зам, зогсоол зэрэг зам тээврийн байгууламжтай холбоотой төлөвлөгөөг шинэчлэн гаргах санал дэвшүүлнэ.

#### 2.10. **Орон зайн төлөвлөлт /Иргэдийн амьдрах орчныг сайжруулах/**

##### а) Үндсэн чиглэл

- Хотын онцлогийг харгалзан үзэж гудамж, талбайн тохижилтыг сайжруулах стратегийг боловсруулж, санал дэвшүүлнэ.
- Хотын төв болон гэр хорооллын тэнцвэртэй хөгжлийг хангах арга хэмжээний талаар санал дэвшүүлнэ.

##### б) Иргэдийн амьдрах орчныг сайжруулах

- Газрын зохион байгуулалт болон хэрэглээний газар зэрэг орон нутгийн нөхцөл байдал нийгэм эдийн засгийн онцлогийг харгалзан амьжиргааны түвшин доогуур айл өрхийн амьжиргааг дээшлүүлэх санал боловсруулах.
- Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, нутаг дэвсгэр тус бүрд соёл, боловсрол, спортын байгууламжуудыг бий болгох, төвийг барих төлөвлөлтийг хийнэ.
- Шинэ суурьшлын бүс, шинээр баригдах орон сууцны хотхонд иргэдэд үйлчлэх соёлын төв бий болгох төлөвлөгөөг дэвшүүлнэ.

#### 2.11. **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /Байгаль орчин, аялал жуулчлал, Хог хаягдлын менежмент, Байгаль орчин хамгаалах/**

##### а) Үндсэн чиглэл

- Хотын тасралтгүй хөгжлийг хангах байгаль хамгаалах төлөвлөгөөний зорилт болон стратегийг боловсруулах.
- Байгаль орчныг урьдчилан бохирдохоос сэргийлэх зарчимтайгаар байгаль, агаар, усны бохирдож буй шалтгааныг судалж авах арга хэмжээг боловсруулах.
- Байгаль орчныг хамгаалах байгууламжийн өнөөгийн байдал болон асуудалтай талыг дүгнэн хүрээлэн буй орчны үндсэн байгууламжийг өргөжүүлэх чиглэлийг бий болгоно.

##### б) Хүрээлэн буй орчныг хамгаалах төлөвлөгөө

- Байгальд ээлтэй технологийг бизнес, хотын хөгжилд ашиглах
  - Хотод хэрэгжүүлэх төсөл төсөл нь байгальд ээлтэй технологи ашиглах, байгаль орчныг хамгаалах стратегийг боловсруулах.
  - Төсөл хэрэгжүүлэх газарт гол, цэцэрлэгт хүрээлэн, ой мод таарч байвал түүнийг хамгаалах талаар төлөвлөж ажиллах.
- Агаар орчин болон усны орчны хамгаалалт

- Утаа багатай түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, агаар бага бохирдуулах тээврийн хэрэгслийг дэмжих, сэргээгдэх эрчим хүчээр хотыг хангах систем байгуулах зэрэг байгаль орчинд хор нөлөөтэй бодисын гадагшилтыг багасгахын тулд стратегийг баримтална.
- Эрчим хүч
  - Цахилгаан, хийн түлш, тосны төрөл, нүүрс бусад шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах.
  - Эрчим хүчээр хангах төлөвлөгөөнд сэргээгдэх эрчим хүчээр хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх.

#### 4.5 Инженерийн дэд бүтцийн төлөвлөлт

##### а) Цэвэр, бохир ус

- Иргэдийн хэрэглээний ус болон үйлдвэрлэлийн усны хангамжийг ялган төлөвлөх шаардлагатай. Усаар хангах хүний тоо, усны хэмжээ, болон усны хувь, үйлдвэрлэлийн хэрэглээний ус хангах хэмжээг таамаглан төлөвлөж байгууламжийг бүрдүүлэх.
- Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслийн усны хэрэгцээг тооцоолон үзэж хангах усны хэмжээ, хаягдах бохир усны хэмжээг тооцож байгууламжийг төлөвлөх.
- Иргэдийн хэрэглээний бохир ус, үйлдвэрийн бохир усны хэмжээг таамаглаж, бохир ус цэвэрлэх төлөвлөгөө гаргах.

##### б) Бусад суурь байгууламжийн төлөвлөгөө

- Бусад суурь байгууламж нь хүн амаас хамаарч төрөл хүрээ нь өөрчлөгддөг ба шаардлагатай хэмжээтэйгээр томруулж, шаардлагатай тохиолдолд шатлалтайгаар таамаглан хангах аргаар төлөвлөнө.

### 5.АЖИЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн үйл ажиллагааны харилцан уялдаа холбоог харгалзан үзэж, нэгэн зэрэг эсвэл зохих дарааллаар гүйцэтгэх ёстой бөгөөд өндөр түвшний удирдлага, зохицуулалт, хэрэгжилт, хяналт шаардагдана. Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн хугацаанд боловсруулна. Тус хугацаанд магадлалын нэгтгэсэн дүгнэлт гаргуулах хугацаа ороогүй болно.

Эхний тайлан: /45 хоногт гүйцэтгэнэ./

- Одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийж судалгааны түвшинд харьцуулсан хувилбар дэвшүүлэн төлөвлөлтийн шийдэл боловсруулах;
- Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийсэн байх;
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ;
- Төлөвлөлтийн хязгаарт байрлаж байгаа төсөл, хөтөлбөрийн хүчин чадлыг тодорхойлсон байх;

Эцсийн тайлан: /45 хоногт гүйцэтгэнэ./

- Төлөвлөлтийн шийдлийг эцэслэн боловсруулсан байх;
- Дундын тайланд өгсөн санал, зөвлөмжийг тусган эцсийн байдлаар хүлээлгэн өгөх.

## 6.ХҮЛЭЭЖ БАЙГАА ҮР ДҮНГҮҮД

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь доор дурдсан бүх баримт бичгийг англи хэл дээр таван хувь бэлтгэж, монгол хэл рүү орчуулна. Эцсийн тайланг бүх мэдээллийн цаасан болон цахим хуулбарын хамт төслийн удирдлагын албанд ирүүлнэ. Англи хэл дээрх тайланг Монгол хэл рүү орчуулах орчуулгын үйлчилгээний бүх зардлыг зөвлөх хариуцна.

2.12. Зөвлөх Үйлчилгээ Үзүүлэгч нь дараах гол үр дүн, тайлангуудыг ирүүлэх ба зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Доорх хүснэгтийн гол агуулга нь урьдчилсан шинж чанартай бөгөөд эцсийн гол агуулгыг Төслийн удирдлагын албатай ярилцаж, төслийг боловсруулахаас өмнө батлах ёстой.

Гарах үр дүнгүүд	Гол агуулга, гаралт	Хугацаа
<b>Ерөнхий үзүүлэлт</b>		
<b>Зөвлөх Эхлэлийн тайлан</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагаа бүрийн нарийвчилсан ажлын хуваарь, төлөвлөгөө;</li> <li>• Ажлын нэгдсэн төлөвлөгөө, хэрэгжилт чухал үе шатууд;</li> <li>• Бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн санал болгож буй үйл ажиллагааны хуваарь;</li> <li>• Хүн хүч, нөөцийг ажилд гаргах зохицуулалт, түүний дотор тодорхой үр дүн;</li> <li>• Зураг төслийг хянах хугацааг тодорхойлсон инженерийн гүйцэтгэлийн хуваарь;</li> <li>• Ерөнхий загвар, зургийн тодорхойлолт;</li> <li>• Хүн хүч, нөөцийг ажилд гаргах зохион байгуулалт, удирдлага төлөвлөгөө;</li> <li>• Бүх анхан шатны хурлын тэмдэглэл, баримт бичиг;</li> <li>• Хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцооны тойм;</li> <li>• Урьдчилсан үнэлгээ, дүгнэлт;</li> <li>• Анхны асуудал/хязгаарлалтууд үүсэх;</li> <li>• Хийсэн үйл ажиллагааны хураангуй;</li> <li>• Үйл ажиллагааны санал болгож буй хөтөлбөрүүд;</li> <li>• Шаардлагатай бол бусад мэдээлэл;</li> </ul>	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 2 сарын дотор
<b>Төлөвлөгөө</b>	Бүх төрлийн салбарын судалгаа, баримт бичиг, мэдээлэл, төслийн дараагийн үе шатны байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэх мэт.	Төслийн удирдлагын албатай ярилцаж, тохиролцоно
<b>Судалгаа, санал асуулга болон асуумж</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хийсэн бүх судалгаа, судалгаа, тооллогын тайлан;</li> <li>• Холбогдох чиглэлээр олон улсын шилдэг туршлагын судалгаа, санал асуулга;</li> <li>• Тогтсон өгөгдөл, мэдээлэл, мэдээллийн сан;</li> <li>• Дижитал, цахим архивын баримтууд;</li> <li>• Бусад бүх судалгаа, тооллого, судалгааг хийсэн.</li> </ul>	3 долоо хоног
<b>Салбарын бодлого Шинэчлэлийн бүрэлдэхүүн хэсэг</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Эцэслэн боловсруулсан бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, хүрээ;</li> <li>• Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, чадавхыг бэхжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө, боломжийн механизм ба маркетингийн</li> </ul>	Төслийн удирдлагын албатай ярилцаж, тохиролцоно

	<p>стратеги, газар ашиглалтын төлөвлөгөө; хотын аж ахуй, хүлэмжийн зохицуулалт гэх мэт;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийг бууруулах судалгаа, ногоон технологийн жагсаалт гэх мэт төрөл бүрийн судалгаануудын материал,</li> <li>• Оролцогч талуудын оролцоо, олон нийтийн хэлэлцүүлгийн талаарх төрөл бүрийн тайлан, чадавхыг бэхжүүлэх сургалт, ажлын хэсгийн хурал</li> </ul>	
<b>Эцсийн тайлангууд болон Төсөл дуусгах тайлан</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол агуулгыг төслийн удирдлагын газар хэлэлцэн батлах ёстой</li> </ul>	<b>Төслийн удирдлагын албатай ярилцаж, тохиролцоно</b>
<b>Нийт хүлээн авах материалын бүрдэл, шаардлага</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хэвлэмэл материал <ul style="list-style-type: none"> <li>- Хэвлэмэл болон цахим хэлбэрийн баримт бичгийг 5 хувь ирүүлэх ба зураглалын материалыг А3-аас А1 хэмжээтэйгээр ирүүлнэ.</li> </ul> </li> <li>2. Цахим баримт бичиг <p>Бичиг баримтууд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын файл /*.doc, *.ppt, *.pdf, *.xlsx/</li> <li>- Батлагдсан баримт бичгийн сканердсан хувь /*.pdf, *.jpg/</li> </ul> <p>Зураглалын материал</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зураглалын материалын ажлын файл /*.dwg, *.shp, *.jpg, *.ppt/</li> <li>- Видео танилцуулга /дэлгэрэнгүй болон товч/</li> <li>- Батлагдсан төслийн сканердсан хувь /*.jpg, *.pdf/</li> </ul> </li> </ol>	<b>Төслийн удирдлагын албатай ярилцаж, тохиролцоно</b>

2.13. Дээр дурдсан бүх баримт бичгийг англи хэл дээр бэлтгэж, монгол хэл рүү хөрвүүлнэ. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь зөвлөх мэргэжилтэн бүрийн хийх ёстой даалгавар, үр дүн, цаг хугацааг тодорхой харуулсан ажлын төлөвлөгөө, цаг хугацааны хуваарийг боловсруулах ёстой. Баримт бичиг, тайлан тус бүрийн агуулгыг төслийн удирдлагын алба хэлэлцэн батлах ёстой.

2.14. Зүйл тус бүрийн холбогдох бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг эцсийн байдлаар, өөрөөр хэлбэл төслийн удирдлагын албанаас хүлээн зөвшөөрч, англи, монгол хэлээр ирүүлсэн тохиолдолд үр дүн дууссан гэж үзнэ. Бүрэн бус ба/эсвэл зөвшөөрөгдөөгүй үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд нэхэмжилсэн төлбөрийг боловсруулахад саатал үүсгэж болзошгүй.

2.15. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь зөвлөх үйлчилгээний мөн чанар нь дээр дурдсан ажил бүрийг дуусгахыг шаарддаг бөгөөд ажил бүр нь тодорхой үр дүнтэй шууд холбоогүй байж болно гэдгийг ойлгох ёстой. Иймд Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь зөвлөх бүр гаргах ёстой бодит үр дүнд тохирсон цагийн хуудсыг үнэн зөв хөтөлж, үр дүнтэй менежментийг хангах үүрэгтэй. Зөвлөх бүрийг бэлтгэсэн ахиц дэвшлийг харуулсан хавсаргасан баримт бичиг нь цагийн хуудсанд бүртгэгдсэн бодит хариу өгөх ёстой.

2.16. Хүлээн авах материалыг хожимдуулсан (хуваарийн дагуу) ирүүлсэн (тийм хоцрогдолтой байх үндэслэлгүйгээр) ба чанарын шаардлага хангаагүйгээс үүдэн гарсан аливаа саатал нь төслийн хэрэгжилтэд хохирол учруулж, төсөл, хөтөлбөрийн ерөнхий гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй. Иймд хүлээн зөвшөөрөгдөөгүй шалтгаан, шалтгааны улмаас саатал гарсан тохиолдолд зөвлөхөөс яаралтай арга хэмжээ авахыг шаардана. Энэхүү хохирлыг багасгах, зохих арга хэмжээ, арга хэмжээний бүх зардлыг зөвлөх

хариуцна; Бүр тодруулбал, хангалтгүй үр дүн, өөрөөр хэлбэл, 3 удаагийн дараалсан тайлбар, санал хүсэлтийн дараа хэрэгцээтэй мэдээлэлгүй тайланг ямар ч төлбөртэй оролтгүйгээр өргөнөөр хянан засварлана.

2.17. Эцсийн тайланг цахим мэдээллийн хэрэгслээр захиалагчид ирүүлнэ. Бүх цахим болон цаасан хуулбарыг хүлээлгэн өгч, тодорхой баримтжуулж, шошго, ангилж, хадгална. Зөвхөн батлагдсан инженерийн нарийвчилсан зураг монгол хэл дээр байж болно.

## 7.БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2.18. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь техникийн даалгаврын шаардлагад заасан үүрэг даалгаврыг гүйцэтгэхэд тохирсон олон улсын болон үндэсний болон нэмэлт мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулж, хамгийн өндөр чанартайгаар ажлыг хэрэгжүүлэх, цаг тухайд нь биелүүлж, багийг удирдах үүрэгтэй. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь техникийн даалгаврын шаардлагад заасан ажлын цар хүрээг хамгийн өндөр чанартайгаар гүйцэтгэхэд шаардагдах бүх техникийн чиглэлээр мэргэшсэн байх ёстой.

2.19. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь дээр дурдсан зураг төслийн ажилд тусгай зөвшөөрөл, энэ төсөлд томилогдсон ажилтны нийгмийн хамгааллын баримт, түүнчлэн тухайн ажилтны мэргэшлийг тогтоох ур чадвар, мэргэшил, ажлын туршлага, мэргэжлийн гэрчилгээ зэргийг бүрдүүлэх ёстой. Зөвлөх болон түүний ажилтнууд нь ажил эрхлэхэд шаардагдах холбогдох лиценз, мэргэжлийн бүртгэлтэй байх ёстой.

2.20. Төслийн удирдлагын газартай өдөр бүр хамтран ажиллах, холбогдох эрх бүхий байгууллагатай холбоо тогтооход хялбар болгох үүднээс зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь Улаанбаатар хотод ажлын албатай байх ёстой. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь энэ талбайн оффисын ашиглалт, засвар үйлчилгээ, мөн даалгаврыг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад бүх зардлыг хариуцна.

2.21. Техникийн даалгаврын шаардлагад заасан бүх үйл ажиллагааг явуулах дараах Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байх ёстой.

## 8.МЭРГЭЖЛИЙН ҮНДСЭН ШААРДЛАГА

2.22. Зөвлөх баг нь зохих чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой бөгөөд дараах ур чадваруудыг эзэмшсэн байна.

Мэргэжилтнүүд	Нарийвчилсан даалгавар ба хүлээгдэж буй үр дүн	Шаардлагатай мэргэшил, туршлага
<p><b>Олон улсын болон дотоодын зөвлөх багийн мэргэжилтнүүдэд тавигдах нийтлэг ерөнхий шаардлага, мэргэжлийн шаардлага</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний концепц, боловсруулалт хийгдэж буй хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж өгөх</li> <li>- Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний боловсруулж буй баримт бичгийг салбар бүрээр судлан хоорондын уялдаа холбоонд дүгнэлт өгөх</li> <li>- Салбар бүрд боловсруулж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах</li> <li>- Дараах салбар бүрээр /мастер төлөвлөгөө/ үе шатны</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өмнө нь гадаадын төсөл хөтөлбөрүүд дээр ажиллаж байсан туршлагатай хөгжиж буй орнууд, ялангуяа хандивлагчдын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүд</li> <li>- Бодлоготой танилцах, Монгол Улсын Засгийн газрын журам,</li> <li>- Үндэсний болон орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажиллах чадвартай;</li> <li>- Дүүрэг, ногоон байгууламжийн талаар гүнзгий мэдлэгтэй үзэл баримтлал;</li> <li>- Сайн менежмент, Англи хэлний сайн мэдлэгтэй, харилцаа холбоо, хүмүүстэй харилцах, урам зориг өгөх ур чадвар хэл (бичгийн болон</li> </ul>



	<p>төсөл хөтөлбөрийг боловсруулах</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Газар ашиглалт, газрын менежментийн төлөвлөлт</li> <li>➤ Иргэний амьдрах орчныг сайжруулах гэр хорооллын стратеги төлөвлөгөө,</li> <li>➤ Авто зам, тээврийн сүлжээний нэгдсэн бодлого</li> <li>➤ Ус хангамж, ариутгах татуургын системийн төлөвлөлт,</li> <li>➤ Инженерийн бэлтгэл арга хэмжээ, Гамшгийн менежмент,</li> <li>➤ Байгаль орчин, аялал жуулчлал, Хог хаягдлын менежментийн салбаруудад боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах</li> <li>➤ Салбарын одоогийн болон шинээр гарч ирж буй шилдэг туршлага, технологийн талаар судалгаа хийж төлөвлөлтөд тусгах;</li> <li>➤ Төслийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах үүднээс төсөлд оролцогч төслийн зөвлөхүүдтэй харилцах, хамтран ажиллах, зохицуулах;</li> <li>➤ Амжилтад хүрэхийн тулд гол оролцогч талууд, холбогдох төрийн байгууллагууд болон бусад холбогдох талуудтай хамтран ажиллана төсөл хэрэгжилт;</li> <li>➤ Төслийн удирдлагын алба, Төсөл хэрэгжүүлэх албанд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, хэрэгжилтийн явцыг ухай бүр тайлагнах;</li> </ul>	<p>ярианы);</p> <ul style="list-style-type: none"> <li>- Багийн гишүүдэд зөвлөгөө өгөх, төслийн болон техникийн чиглэлээр заавар зөвлөгөө өгөх чадвартай асуудал, эрсдэлийн удирдлагын журам болон хангах чадавхыг бэхжүүлэх сургалт янз бүрийн хэлбэрүүд; Маш хүчтэй аналитик ур чадвар, үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлж, түүнд тохирсон байх чадвартай шийдэл;</li> <li>- Ажил үүргээ хэрэгжүүлэхэд санаачилгатай, шийдвэр гаргах, бие даан ажиллах чадвартай;</li> <li>- Олон улсын байгууллагатай нягт хамтран ажиллах, зохицуулах чадвартай Холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэг эрчим хүчний хэмнэлт, нүүрстөрөгчийн ялгаралттай холбоотой үйлчилгээ, системийн талаар сайн ойлголттой байх, эрчим хүчтэй холбоотой суурилуулалт хийх;</li> <li>- Зураг төслийн программууд дээр ажиллах ур чадвартай байх, 3 хэмжээст программын ур чадвартай байх;</li> <li>- Эрчим хүчний загварчлалын программ хангамжийн ур чадвартай байх;</li> </ul>
--	---	---

## 9.БУСАД

2.23. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагад 7 хоног бүр төслийн ажлын явцын тайланг ирүүлнэ.

2.24. Цахим шуудан, телефакс зэрэг бүх захидал харилцааг зохих ёсоор тодорхойлж, төслийн дугаар, төслийн нэр, тодорхой сэдвийг агуулсан байх ёстой.

2.25. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь захиалагч, зөвлөхийн оролцсон бүх хурлын тэмдэглэлийг бэлтгэж, гурав (3) хоногийн дотор захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлж, хянан баталгаажуулна.

2.26. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрөөр зааснаас бусад тохиолдолд даалгаврыг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардагдах бүх тээвэр, харилцаа холбоо, ложистикийн дэмжлэгийг хариуцна.

**ЗӨВШӨӨРСӨН:**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Л.ХОСБАЯР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАТЗОРИГ

**ХЯНАСАН:**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАСГИЙН ДАРГА

Б.ГАНТУЛГА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ,  
ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.АМГАЛАН

**БОЛОВСРУУЛСАН:**

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

М.ШИЖИРБАЯР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

С.ДАЛАНЖАРГАЛ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ХАН-УУЛ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ХЭСЭГЧИЛСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

М.МЭНДСАЙХАН

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ОЮУНТУЯА

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДОТООД ХЯНАЛТ, ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.БАДАМХАНД